

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
	2.1. Оршил	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
	2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	7
	2.9. Анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
	2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
	2.11. Шилэн дансны мэдээлэл	8
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
	4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
	4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
	4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
	4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
	4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ИХ СУРГУУЛИУДЫН ХОТХОНЫ
АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ЗАХИРГААНЫ
ДАРГА Ю.ЭНХБАТ ТАНАА

2019.02.28 № 06/352
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус захиргааны дарга Ю.Энхбат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон бүртгэлтэй байгаа хөрөнгийн бүртгэлийг холбогдох дээд байгууллагаар шийдвэрлүүлэх, зардлыг төсөвт тусгуулж батлагдсан ангиллын дагуу зарцуулан ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 09-наас 2019 оны 2 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 24-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн чанарын хяналтын менежер Д.Туяа анхан шатны чанарын хяналт хэрэгжүүлэхээр, "Мэдээлэл аудит" ХХК-ийн захирал Д.Товуудорж, Аудитор А.Гэрэлмаа, шинжээч С.Наранцэцэг нар аудитыг хариуцаж хэрэгжүүлэв.

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газар-т 2019 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн №08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа нь Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэн, үндэсний их сургуулиудыг чадавхжуулан сургалт, судалгаа, шинжлэх ухаан, үйлдвэрлэл бизнесийн холбоог бэхжүүлж олон улсад өрсөлдөх чадвартай дээд боловсролын тогтолцоог эх орондоо бий болгон, ажиллаж амьдрах таатай нөхцөл бүрдсэнээр баялагт суурилсан эдийн засгаас мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих үндэс суурийг тавих гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

2.5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын даргын 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/20 тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахг шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон шалтгаан нь санхүүжилт улсын төсвөөс хийгдэг тул зардлыг нарийвчлан хянаж материаллаг сууриар сонгох нь зүйтэй гэж үзлээ.

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2018 оны *Нийт зардал* 345,898.3 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 3,458.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	1,376.7	
	Дүн	2	1,376.7	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

2.9.АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 193 дугаар тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчид хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах, Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг зохион байгуулахаар шийдвэрлэсний дагуу Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны нэр дээр эзэмших эрхийн гэрчилгээтэй, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын мэдээллийн санд бүртгэлтэй байсан газрыг дахин үнэлгээ хийж санхүүгийн тайланд 758,497,530.0 мянган төгрөгөөр газрыг тусгасан.

2.10. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 254,787.5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. 100% улсын төсвөөс санхүүждэг. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 252,382.3 мянган төгрөг буюу 99,1 хувьтай байгаа бөгөөд 2018 оны харилцах дансны үлдэгдэл 2,405.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

2.11. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. 2018 онд оруулах ёстой 161 мэдээллээс 159-ыг оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийг бүрэн биелүүлсэн байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Мөнгөн гүйлгээний журналд тусгасан дүнг суурь болгож Мөнгөн гүйлгээний тайлан, Төсвийн гүйцэтгэлийн тайлан, Санхүүгийн үр дүнгийн тайланд хийсэн аудитын сорилоор бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд төсөвт тусгагдаагүй аж ахуйн материалын 1,376.7 мянган төгрөгийн зардлыг оруулсан байна.

Энэ нь батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна "Төсвийн тухай хууль", "Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын хавралт №1-д заасан журам зэргийг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн гүйцэтгэлийн тайлан буруу илэрхийлэгдэх, Төсвийн тухай хууль хэрэгжихгүй байх,

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн "6.2.2.д жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх; ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлэх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Контторын аж ахуйн бага үнэтэй материал, зочдын цай, кофе гэх мэтийн зардлыг "Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж" зардлаас бүртгэсэн ба Төрийн сан хянаж, зөвшөөрснөөр гүйлгээг батлуулж, тайланд тусгасан.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн өмчийн хэсэгт тусгагдсан Төрийн өмчийн дүн Улсын бүртгэлийн гэрчилгээний дүнгээс зөрүүтэй байна.

Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Бүртгэлтэй байгаа холбогдох хөрөнгүүдийн бүртгэлийг удирдах дээд байгууллагаар шийдвэрлүүлэх,

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Тус 318,363.7 мянган төгрөгийн дүнд 304,969.6 мянган төгрөгийн биет бус хөрөнгө /судалгааны материалууд/ 13,394.1 мянган төгрөгийн автомашин БСШУЯ-аас ирснийг зах зээлийн үнээр бүртгэсэн зэргийг 2011 оны жилийн эцсийн тайланд “Төрийн өмч” дансанд бүртгэсэн нь дарга Ц.Энхболд, нягтлан бодогч И.Дээшин нарын бүртгэлийн алдаа гэж үзэж байна. Тухайн ажил гүйлгээнүүдийг “Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого” дансанд бүртгэж, “Тайлант үеийн үр дүн болох байсан. Тиймээс “Хуримтлагдсан үр дүн” данс руу шилжүүлэх боломжтой эсэхийг тодруулж өгнө үү!

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 07 дугаар 01-ний дотор багтаан хариу ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>25,761,874.51</u>	<u>27,235,204.51</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
31110	Төгрөг	00.00	00.00
33	АВЛАГА	00.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	25,761,874.51	27,235,204.51
354	Хангамжийн материал	25,761,874.51	27,235,204.51
35410	Бичиг хэргийн материал	224,299.00	186,000.00
35420	Аж ахуйн материал	60,000.00	60,000.00
35440	Түлш, шатах тослох материал	886,608.51	1,876,737.51
35470	Бусад хангамжийн материал	24,590,967.00	25,112,467.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,427,403,850.08</u>	<u>759,832,349,633.60</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,427,403,850.08	759,832,349,633.60
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	48,894,267.78	49,271,309.51
39203	Авто-тээврийн хэрэгсэл	130,000,000.00	130,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-88,472,222.44	-110,138,889.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27,058,400.00	52,014,390.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-24,392,192.29	-26,378,544.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,259,300.00	9,259,300.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,195,957.49	-6,121,887.33
39217	Ном	636,940.00	636,940.00
393	Биет бус хөрөнгө	1,378,509,582.30	759,783,078,324.09
39301	Програм хангамж	1,193,100.00	1,193,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,193,100.00	-1,193,100.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,641,675,903.20	760,139,205,903.20
39304	Хуримтлагдсан элэгдэл	-263,166,320.90	-356,127,579.11
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,453,165,724.59</u>	<u>759,859,584,838.11</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
413	Өглөг	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,453,165,724.59</u>	<u>759,859,584,838.11</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,453,165,724.59	759,859,584,838.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	320,863,673.00	758,818,393,673.00
51101	Өмч: - төрийн	320,863,673.00	320,863,673.00

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51106	Эздийн өмчийн бусад хэсэг	00.00	758,497,530,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,132,302,051.59	1,041,191,165.11
51210	Өмнөх үеийн үр дүн	1,132,302,051.59	1,132,302,051.59
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-91,110,886.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,453,165,724.59</u>	<u>759,859,584,838.11</u>

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	205,183,500.00	254,787,500.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	205,183,500.00	254,787,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	205,183,500.00	254,787,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	205,183,500.00	254,787,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	329,124,235.77	345,898,386.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	329,124,235.77	345,898,386.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	322,150,079.66	343,493,247.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	111,036,539.00	114,823,016.00
210101	Үндсэн цалин	111,036,539.00	114,823,016.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,710,621.33	13,946,449.57
210201	Тэтгэврийн даатгал	8,138,977.21	9,416,241.28
210202	Тэтгэмжийн даатгал	1,162,711.03	1,177,030.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	909,048.82	827,071.77
210204	Ажилгүйдлийн даатгал	227,262.21	229,646.04
210205	Эрүүл мэндийн даатгал	2,272,622.06	2,296,460.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,385,000.00	21,000,000.00
210304	Байрны түрээс	16,385,000.00	21,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,667,570.50	11,290,515.00
210401	Бичиг хэрэг	1,095,101.00	1,585,249.00
210402	Тээвэр, шатахуун	8,099,469.50	8,102,921.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	174,000.00	717,345.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	299,000.00	885,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,135,300.00	5,043,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	43,500.00
210604	Урсгал засвар	2,135,300.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,387,776.56	5,115,000.00
210702	Дотоод албан томилолт	9,387,776.56	5,115,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,995,997.00	53,734,560.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,268,197.00	46,541,230.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	990,000.00	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	1,492,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193,500.00	193,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	52,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,482,900.00	1,485,000.00

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,400.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	122,831,275.27	118,540,206.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	122,831,275.27	117,540,206.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,974,156.11	2,405,139.43
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,187,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,187,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,787,156.11	2,405,139.43
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	00.00
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	00.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,787,156.11	2,405,139.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-123,940,735.77</u>	<u>-91,110,886.48</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-123,940,735.77</u>	<u>-91,110,886.48</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	205,183,500.00	254,787,500.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
110	Орлогын албан татвар	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	205,183,500.00	254,787,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	205,183,500.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	205,183,500.00	00.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	254,787,500.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	254,787,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	205,183,500.00	229,831,510.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	205,183,500.00	229,831,510.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	198,209,343.89	227,426,370.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	111,036,539.00	114,823,016.00
210101	Үндсэн цалин	111,036,539.00	93,584,216.00
210102	Нэмэгдэл	00.00	11,074,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	10,164,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,710,621.33	13,946,449.57
210201	Тэтгэврийн даатгал	8,138,977.21	9,416,241.28
210202	Тэтгэмжийн даатгал	1,162,711.03	1,177,030.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	909,048.82	827,071.77
210204	Ажилгүйдлийн даатгал	227,262.21	229,646.04
210205	Эрүүл мэндийн даатгал	2,272,622.06	2,296,460.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,385,000.00	21,000,000.00
210304	Байрны түрээс	16,385,000.00	21,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,317,200.00	12,763,845.00
210401	Бичиг хэрэг	1,319,400.00	1,546,950.00
210402	Тээвэр, шатахуун	7,524,800.00	9,093,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	174,000.00	717,345.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	299,000.00	1,406,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,135,300.00	5,043,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	43,500.00
210604	Урсгал засвар	2,135,300.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,628,686.56	5,115,000.00
210702	Дотоод албан томилолт	8,628,686.56	5,115,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,995,997.00	53,734,560.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,268,197.00	46,541,230.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	990,000.00	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	1,492,830.00

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210804	Тээврийн хэрэгслийн татвар	193,500.00	193,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	52,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,482,900.00	1,485,000.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,400.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,974,156.11	2,405,139.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,187,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,187,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,787,156.11	2,405,139.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,787,156.11	2,405,139.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	24,955,990.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	24,955,990.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	24,955,990.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	24,955,990.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	24,955,990.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-24,955,990.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээн ий нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	320,863,673.00	00.00	1,256,242,787.36	00.00	1,577,106,460.36
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	320,863,673.00	00.00	1,256,242,787.36	00.00	1,577,106,460.36
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-123,940,735.77	00.00	-123,940,735.77
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	320,863,673.00	00.00	1,132,302,051.59	00.00	1,453,165,724.59
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	320,863,673.00	00.00	1,132,302,051.59	00.00	1,453,165,724.59
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	758,497,530,000.00	00.00	-91,110,886.48	00.00	758,406,419,113.52
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	758,818,393,673.00	00.00	1,041,191,165.11	00.00	759,859,584,838.11

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	254,787,500.00	252,382,360.57	2,405,139.43	99.10%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	254,787,500.00	252,382,360.57	2,405,139.43	99.10%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	254,787,500.00	252,382,360.57	2,405,139.43	99.10%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	116,620,700.00	114,823,016.00	1,797,684.00	98.50%
210101	Үндсэн цалин	94,375,300.00	93,584,216.00	791,084.00	99.20%
210102	Нэмэгдэл	12,081,400.00	11,074,800.00	1,006,600.00	91.70%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,164,000.00	10,164,000.00	0.00	100.00%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,994,400.00	13,946,449.57	47,950.43	99.70%
210201	Тэтгэврийн даатгал	9,329,600.00	9,416,241.28	-86,641.28	100.90%
210202	Тэтгэмжийн даатгал	1,166,200.00	1,177,030.16	-10,830.16	100.90%
210203	ҮОМШӨ-ний даатгал	933,000.00	827,071.77	105,928.23	88.60%
210204	Ажилгүйдлийн даатгал	233,200.00	229,646.04	3,553.96	98.50%
210205	Эрүүл мэндийн даатгал	2,332,400.00	2,296,460.32	35,939.68	98.50%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,000,000.00	21,000,000.00	0.00	100.00%
210304	Байрны түрээс	21,000,000.00	21,000,000.00	0.00	100.00%
2104	Хангамж, бараа материалын зардал	12,789,400.00	12,763,845.00	25,555.00	99.80%
210401	Бичиг хэрэг	1,489,400.00	1,546,950.00	-57,550.00	103.90%
210402	Тээвэр, шатахуун	8,000,000.00	9,093,050.00	1,093,050.00	113.70%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,000.00	717,345.00	1,082,655.00	39.90%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,406,500.00	93,500.00	93.80%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,000,000.00	29,999,490.00	510.00	100.00%
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,000,000.00	24,999,490.00	510.00	100.00%
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00%
2107	Томилолт, зочны зардал	5,115,000.00	5,115,000.00	0.00	100.00%

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	5,115,000.00	5,115,000.00	0.00	100.00%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,268,000.00	53,734,560.00	533,440.00	99.00%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,558,000.00	46,541,230.00	16,770.00	100.00%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00	-	100.00%
210803	Даатгалын үйлчилгээ	2,000,000.00	1,492,830.00	507,170.00	74.60%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	193,500.00	6,500.00	96.80%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	22,000.00	3,000.00	88.00%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,485,000.00	1,485,000.00	0.00	100.00%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1000000	1000000	0.00	100.00%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00%
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12	10	2	83.30%
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.00%
620002	Гүйцэтгэх ажилтан	10	8	2	80.00%
620003	Үйлчлэх ажилтан	1	1	0	100.00%

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд	Аудитын код:
2019.02.23			САГ-2019/83/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Их сургуулиудын хотхон ашиглалтын өмнөх захиргаа		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Төсөвт тусгагдаагүй аж ахуйн материалын зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд оруулан тайлагнасан.	1376.7	Зөвлөмж өгөх	Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны Дарга, нягтлан бодогч	Ю.Энхбат У.Ганчимэг
2	Санхүүгийн тайлангийн өмчийн хэсэгт тусгагдсан Төрийн өмчийн дүн Улсын бүртгэлийн гэрчилгээний дүнгээс зөрүүтэй.		Зөвлөмж өгөх	Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны Дарга, нягтлан бодогч	Ю.Энхбат У.Ганчимэг
	Дүн	1376.7			

[illegible]

[illegible]